

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 26/3

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт удирдав. Тус ээлжит хурлаар банк, санхүүгийн салбарын өнөөгийн байдал, системийн эрсдэлийн шинжилгээний үр дүн, макро зохистой бодлогын арга хэмжээний талаар хэлэлцэж, бодлогын шийдвэрийг гаргалаа.

Хуралдаанаар Монголбанкны Санхүүгийн тогтвортой байдлын газраас банк, санхүүгийн системийн эрсдэлийн шинжилгээний үр дүнгийн талаар МБХ-ны гишүүдэд танилцуулав. Танилцуулгын эхний хэсэгт банк, санхүүгийн системийн мөчлөгийн эрсдэлийн нөхцөл байдал буюу зээлийн өсөлт, хөрөнгийн үнэ, зээлийн чанарын шинжилгээний үр дүнг танилцууллаа. Тодруулбал, санхүүгийн мөчлөгийг тодорхойлдог гол бүрэлдэхүүн үзүүлэлтүүд болох зээлийн өсөлт, зээл ба ДНБ-ий харьцаа буурч, мөчлөг илүү тэнцвэртэй түвшинд шилжсэнийг онцоллоо. 2026 оны 2 дугаар сарын байдлаар банкны системийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт 14.3 хувьтай байгаагийн дийлэнх буюу 9.6 нэгж хувийг бизнесийн зээлийн өсөлт бүрдүүлж байна. Бизнесийн зээл дотроо уул уурхай, барилга, худалдааны салбаруудад төвлөрч байгаа бол иргэдийн хэрэглээний зээлийн өсөлт өмнөх жилүүдтэй харьцуулахад саарсан нь Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний нөлөөтэй холбоотой байна.

Банкны салбарын нийт зээлийн чанарын харьцаа үзүүлэлт тогтвортой байгаа бөгөөд үүн дотроо иргэдийн зээлийн чанаргүйдэл мөн тогтворжиж байна. Энэ оны 2 дугаар сарын байдлаар банкны салбарын анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хувь харгалзан 3.4 болон 5.2 хувьд хүрч, анхаарал хандуулах зээлийн өсөлт өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар буурав. Үүнд анхаарал хандуулах ангилалд байгаа хэрэглээний зээлийн өсөлт саарсан нь голлон нөлөөлснийг дурдав.

Хурлын дараагийн хэсэгт бүтцийн эрсдэлийн шинжилгээ буюу банкны эрсдэл даах чадвар, долларжилт, ханшийн эрсдэл, санхүүгийн байгууллагуудын харилцан хамаарал, давхар зээлийн шинжилгээний үр дүнг танилцууллаа. Банкны системийн төлбөрийн чадвар, хөрвөх чадвар, ханшийн эрсдэл болон төвлөрлийн харьцаа үзүүлэлтүүд зохистой харьцааны доод шаардлагыг хангаж байна. Түүнчлэн, Монголбанкнаас авч хэрэгжүүлж байгаа макро зохистой бодлогын арга хэмжээний үр дүнд банк болон бусад санхүүгийн салбарын хоорондын хамаарлын эрсдэл, иргэдийн давхар зээлийн эрсдэл буурч байгаа талаар мэдэгдэв.

Системийн эрсдэлийн шинжилгээний хүрээнд хийсэн банкны салбарын төлбөрийн чадварын (solvency) стресс тестийн үр дүнд макро эрсдэлийн хүчин зүйлсийн суурь болон хувилбар төсөөллийн үед банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон эрсдэл даах чадавх нийт системийн хэмжээнд зохистой түвшинд хадгалагдахаар байгааг мэдээлэв.

Мөн сүүлийн жилүүдэд банкны салбарын нийт эх үүсвэрт гадаад эх үүсвэрийн эзлэх хувь өсөж, улмаар дотоодын зээлийг банкны хамгийн тогтвортой эх үүсвэрт тооцогдох иргэд, аж ахуйн нэгжийн хадгаламжаас гадна гадаад зээл, бондын эх үүсвэрээр санхүүжүүлэх

хандлага нэмэгдэж байна. Тухайлбал, банкуудын гадаад зах зээлээс татсан бонд болон зээлийн нийлбэр дүн нь банкны салбарын нийт эх үүсвэрийн 19 орчим хувийг бүрдүүлж, банкны салбарын зээл ба хадгаламжийн харьцаа 138 орчим хувьд хүрснийг онцлов.

Ийм нөхцөлд гадаад орчны тодорхой бус байдал өндөр хэвээр хадгалагдаж, олон улсын санхүүгийн зах зээлийн нөхцөл богино хугацаанд өөрчлөгдөх эрсдэлтэй байгаа нь банкуудын гадаад санхүүжилтийн өртөг, хүртээмжид нөлөөлж болзошгүйг дурдав. Иймд санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, банкны салбарын актив, пассивын хугацааны зөрүүг бууруулах, мөн гадаад эх үүсвэрийн бүтцийг илүү урт хугацаатай, тогтвортой чиглэлд шилжүүлэх зорилгоор “банкны гадаад зах зээлээс 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хойш шинээр татсан 360 хоногоос 3 жил хүртэлх хугацаатай гадаад валютын бонд болон зээлийн эх үүсвэрийн 25 хувьтай тэнцэх дүнг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрт хамруулах” бодлогын саналыг МБХ-ны гишүүдэд танилцуулав.

Монголбанк нь Ковид-19 цар тахал болон геополитикийн нөхцөл байдлын үед банкуудын гадаад санхүүжилтийн эх үүсвэрийг дэмжих зорилгоор үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Тухайлбал, Мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр 2020 оны эхнээс гадаад зах зээлээс 3 ба түүнээс дээш жилийн хугацаатайгаар шинээр татсан бонд, зээлийн эх үүсвэрийг заавал байлгах нөөцийн шаардлагаас түр хугацаанд чөлөөлсөн. Улмаар 2022 оны гуравдугаар улиралд энэ зохицуулалтыг өргөжүүлж, 360 хоногоос 3 хүртэлх жилийн хугацаатайгаар гадаад зах зээлээс шинээр татсан бонд, зээлийн эх үүсвэрийг мөн түр хугацаанд чөлөөлөхөөр шийдвэрлэснийг дурдав.

Харин өнөөгийн нөхцөлд санал болгож буй энэхүү бодлогын арга хэмжээ нь санхүүгийн салбарт эмзэг байдал хуримтлагдахаас урьдчилан сэргийлэх, банкуудын богино болон дунд хугацаатай гадаад эх үүсвэр татах сэдлийг бууруулах, илүү урт хугацаатай, тогтвортой эх үүсвэр татахыг дэмжсэн, банкны актив болон пассивын хугацааны нийцтэй байдлыг сайжруулахад чиглэж байгааг тэмдэглэв.

МБХ-ны гишүүд бодлогын саналын банкны ашигт ажиллагаанд үзүүлэх нөлөөллийн талаар тодруулав. Монголбанкнаас гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээ одоогоор 19 хувь байгаа тул бодит нөлөө нь шинээр татах эх үүсвэрийн 4.75 хувь буюу харьцангуй бага болохыг онцоллоо.

Ийнхүү МБХ-ны гишүүд банкны гадаад зах зээлээс 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хойш шинээр татсан 360 хоногоос 3 жил хүртэлх хугацаатай гадаад валютын бонд болон зээлийн эх үүсвэрийн 25 хувьтай тэнцэх дүнг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрт хамруулах саналыг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжсэнээр МБХ-ны ээлжит хуралдаан өндөрлөв.

Бодлогын саналын шийдвэр

